

МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2012 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 344

Улаанбаатар хот

“Зээлийн батлан даалтын сангийнүйл ажиллагааны  
шалгуур үзүүлэлт, хяналт тавих журам”-ыг батлах тухай

Санхүүгийнзохицуулаххорооныэрхзүйнбайдлынтухайхуулийн 6.1.2, Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 14.2, 16.1 дэх заалтыг тус тусүндэслэнСанхүүгийнзохицуулаххорооноос ТОГТООХ нь:

1. “Зээлийн батлан даалтын сангийнүйл ажиллагаанышалгуур үзүүлэлт, хяналт тавих журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан журмын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

*/Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 463 дугаар тогтоолоор орсон өөрчлөлтийг тусгав/*

## **ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ**

### **Нэг . Нийтлэг үндэслэл**

1.1. Энэ журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/ - ноос Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд заасан эрх зүргийн хүрээнд Засгийн газар үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагч болон давхар батлан даагчаар орж байгаа Зээлийн батлан даалтын сан /цаашид “Сан” гэх/-гийн үйл ажиллагаанд учирч болзошгүй санхүүгийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийг тодорхойлох, холбогдох хууль тогтоомж, журам, зааврын хэрэгжилтэд хяналт тавих, гарсан зөрчлийг арилгуулахад оршино.

1.2. Сан нь Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 3 дугаар бүтэцт заасан үйл ажиллагааг эрхлэхдээ дээрх хууль, холбогдох бусад хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн Хороо болон зохих төрийн байгууллагуудаас баталсан бодлогын баримт бичиг, журам, зааврыг удирдлага болгоно.

### **Хоёр. Санд тавигдах шалгуур үзүүлэлт**

2.1. Сан нь дараах шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байна. Үүнд:

2.1.1 Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 6.2, 8.1 дэх заалтын дагуу дүрмийг батлах, түүнд нэмэлт өөрчлөлт оруулахдаа Хорооноос зөвшөөрөл авсан байх;

2.1.2 өөрийн хөрөнгө нь 5,000,000,000.0 /таван тэрбум/ төгрөгөөс доошгүй мөнгөн хөрөнгөтэй байх;

2.1.3 мөнгөн хөрөнгийг банкин дахь өөрийн харилцах, хадгаламж, Засгийн газрын өрийн бичиг болон Хорооноос зөвшөөрсөн бусад хэлбэрээр байршуулах;

2.1.4 энэ журмын хавсралтын дагуу батлан даалтын мэдээ, зээлийн эргэн төлөлтийн сар бүрийн тайланг дараа сарын 10-ны, улирлын санхүүгийн тайланг улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор тус тус Хороонд ирүүлэх;

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 463 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

2.1.5 зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан дотооддоо мөрдөхөөр батлан гаргасан журам, зааварт өөрчлөлт орсон тухай бүр Хороонд мэдэгдэх;

2.1.6 нэг зээлдэгч /жижиг, дундүйлдвэр эрхлэгч/-д гаргах зээлийн батлан даалтын хэмжээ нь банк, санхүүгийн байгууллагаас авах тухайн зээлийн 60 хүртэлх хувь буюу Сангийн өөрийн хөрөнгийн 10 хувиас хэтрэхгүй байх;

2.1.7 гаргасан зээлийн батлан даалтын нийт хэмжээ нь өөрийн хөрөнгийг 10 дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй байх;

2.1.8 өөрийн хөрөнгийн хүрэлцээний шалгуур үзүүлэлтийг тооцохдоо өөрийн хөрөнгийг нийт активт харьцуулж тооцох ба зохистой харьцаа нь 10 хувиас доошгүй байх; /өөрийн хөрөнгийн хүрэлцээ гэж гарч болзошгүй алдагдлыг бүрэн нөхөөд цаашид үйл ажиллагаагаа хэвийн, эрсдэлгүй явуулахад хүрэлцэх хэмжээний өөрийн хөрөнгөтэй байгаа эсэхийг хэлнэ/;

2.1.9 төлбөр түргэн гүйцэтгэх чадварын шалгуур үзүүлэлтийг тооцохдоо түргэн борлогдох активын үнэг бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгөд харьцуулж тооцох ба зохистой харьцаа нь бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн 5 хувиас доошгүй байх;

2.1.10 өөрийн хөрөнгийн доод хэмжээ болон өөрийн хөрөнгө, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа хангахгүй болсон тохиолдолд хөрөнгө оруулагчид оруулсан хөрөнгийн хэмжээндээ хувь тэнцүүлэн дахин хөрөнгө оруулах, эсхүл аль нэг хөрөнгө оруулагч дангаараа буюу хэд хэдэн хөрөнгө оруулагч хамтран хөрөнгө оруулах замаар хөрөнгийн дутууг нөхөх, энэ талаар Хороонд тухай бүр мэдээлэх;

2.1.11 Сан нь батлан даалтынүүрэг гүйцэтгэх чадварыг хангах үүднээс эрсдэлийн сантай байна;

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 11 дүгээр сарын 20 - ны өдрийн 463 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

2.1.12 Эрсдэлийн санг тайлант хугацааны эцэс дэх цэвэр орлогоос түүний 50-иас доошгүй хувиар байгуулна. Эрсдэлийн сангийн хөрөнгийг банкинд хадгаламж хэлбэрээр байршуулах бөгөөд үйл ажиллагаанд зарцуулахыг хориглоно.

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 11 дүгээр сарын 20 - ны өдрийн 463 дугаар тогтоолоор нэмсэн/*

2.2. Сан нь нь зээлийн батлан даалт гаргахдаа дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

2.2.1. зээл олгох банк, санхүүгийн байгууллагын дүгнэлтэд үндэслэн зээлийн батлан даалтын шийдвэр гаргахыг мөн зээлийн батлан даалт хүсэгч жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн санхүү, удирдлагын чадавхи, бизнес төлөвлөгөө болон бусад шаардлагатай мэдээлэлтэй танилцаж, эрсдэлийн үнэлгээ хийсэн байх;

2.2.2. шаардлагатай гэж үзвэл, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн эрхэлж байгаа болон эрхлэх бизнесийн үйл ажиллагааны өмжлөл байдлыг газар дээр нь шалгаж, танилцсан байх;

2.2.3. шаардлагатай гэж үзвэл жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийг тухайн нэр төрлийн даатгалын үйлчилгээнд хамрагдсан байхыг шаардах;

2.2.4. жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн өргөдлийг ажлын 10 хоногийн дотор хянан шийдвэрлэх ба өргөдлийг хүлээн авсан хугацааг шаардлага хангасан баримт бичгийн бүрдлийг бүрэн хангасан өдрөөс эхлэн тооцох;

2.2.5. жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн өргөдөл, холбогдох баримт бичигт хийсэн эрсдэлийн үнэлгээ болон зээл олгох банк, санхүүгийн байгууллагын дүгнэлтэд үндэслэн гаргасан зээлийн батлан даалт гаргах, эсэх тухай шийдвэрийг жижиг, үйлдвэр эрхлэгч болон зээл олгох банк, санхүүгийн байгууллагад албан ёсоор хариу мэдэгдэх;

2.3. Сан нь зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэхдээ дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

2.3.1. зээлийн батлан даалтын гэрээ байгуулагдсан өдрөөс хойш банк, санхүүгийн байгууллагаас сард нэгээс доошгүй удаа зээлдэгч /жижиг, дунд үйлдвэр эрхлэгч/ -ийн зээлийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлт, хэрэгжилтийн талаар мэдээлэл авах;

2.3.2. зээлийн батлан даалтын гэрээ байгуулагдсан өдрөөс хойш жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн санхүү, бизнесийн үйл ажиллагаанд хяналт тавих, холбогдох бүртгэл, тайлан, мэдээг шаардах;

2.3.3. зээлийн батлан даалтын үйл ажиллагаанаас бий болсон хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулах зорилгоор барьцаа хөрөнгийг бусдад худалдах, хуулиар өвшөөрсөн бусад арга хэмжээнд оролцох;

2.3.4. зээлийн батлан даалтын гэрээг бичгээр байгуулж, нотариатаар гэрчилсэн байх;

2.3.5. журмаар тогтоосны дагуу зээлийн батлан даалтын гэрээнд заасан үйлчилгээний шимтгэл хураамжийг жижиг, дунд үйлдвэр эрхлэгчээс авах.

2.4. Сангийн мөнгөн хөрөнгийг Хорооноос өвшөөрсөн бусад хэлбэрээр байршуулахдаа Хорооноос баталсан шийдвэрийг үндэслэл болгоно.

### **Гурав. Хориглох зүйл**

3.1. Зээлийн батлан даагч нь дараах үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:

3.1.1. Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 3 дугаар бүлэгт зааснаас өөр үйл ажиллагаа эрхлэх.

3.1.2. зээлийн батлан даалтын үйл ажиллагааны талаар буруу, ташаа зар сурталчилгаа хийх, мэдээ мэдээлэл өгөх;

3.1.3. санхүүгийн тайлан тэнцэлд тусгагдаагүй эх үүсвэрийг үйл ажиллагаандаа ашиглах;

### **Дөрөв. Хяналт, хариуцлага**

4.1. Холбогдох хууль тогтоомж болон журмын хэрэгжилтэд Хороо хяналт тавина.

4.2. Сангийн үйл ажиллагаанд эрсдэл үүсч болзошгүй гэж үзвэл Хороо дараах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлнэ:

4.2.1. өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх талаар хугацаатай үүрэг даалгавар өгөх;

4.2.2. зээлийн батлан даалт нэмж гаргахыг зогсоох, хязгаарлах.

4.3. Зээлийн батлан даалтын сангийн хууль тогтоомжийг өрчсөн этгээдэд Хорооны хянан шалгагч нь тус хуулийн 18.1 дэх хэсэгт заасан захиргааны хариуцлага ногдуулна.

## **САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО**

Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 11 дүгээр сарын  
28-ны өдрийн 344 дүгээр тогтоолоор  
батлагдсан “Зээлийн батлан даалтын сангийн үйл  
ажиллагааны шалгуур үзүүлэлт,  
хяналт тавих журам”-ын хавсралт

### БАТЛАН ДААЛТ МЭДЭЭ

20...оны ... дугаар сарын ...-ны өдрийн байдлаар

д/д	Зээлдэгчийн овог нэр	Зээл олгосон банк	Хүссэн зээлийн хэмжээ /төгрөгөөр/	Зээлийн хугацаа	Батлан даалтын хэмжээ /төгрөгөөр/	Батлан даалтын хувь	Батлан даалтын шимтгэлийн дүн /төгрөгөөр/	Өөрийн хөрөнгөд эзлэх хувь

Жич: Зээлдэгч тус бүрээр мэдээллийг дэлгэрэнгүй гаргана.

### ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН ТАЙЛАН

20...оны ... дугаар сарын ...-ны өдрийн байдлаар

д/д	Зээлдэгчийн нэр	Зээл олгосон банк	Олгосон зээлийн хэмжээ /төгрөгөөр/	Зээлийн үлдэгдэл /төгрөгөөр/	Зээлийн ангилал	Тайлбар

Жич: Тайлбарт зээлийн хугацаа хэтэрсэн нөхцөлд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар тодорхой бичнэ.

Тамга

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ...../овог нэр/  
НЯГТЛАН БОДОГЧ: ...../овог нэр/

*/Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 463 дугаар тогтоолоор нэмсэн/*